

АЖЛЫН ДААЛГАВАР

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.12.4 дэх заалт, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн дүрмийн 3.1.1 дэх заалтын дагуу дараах зорилгын хүрээнд ажлын даалгаврыг гүйцэтгэнэ.

Судалгааны нэр: Татварын таатай орчин бүрдүүлэх цогц судалгаа

Зорилго: Монгол Улсын өнөөгийн татварын тогтолцоонд дүн шинжилгээ хийж, бусад улс орнуудын татварын тогтолцоотой харьцуулан судалж, Монгол Улсад хамгийн оновчтой татварын тогтолцоог санал болгох

Хамрах хүрээ:

Агуулгын хувьд: Татварын хувь хэмжээний талаар агуулгын хувьд нарийвчлан судлах

Хэлбэрийн хувьд: Судалгааны бүтээл нь цаасан хэлбэртэй байхаас гадна шийдвэр гаргагчдад ойлгомжтой байхын тулд энгийн хэрэглээний программчлалын түвшинд хийгдсэн байна

Судалгааны түүврийн хувьд: Өндөр хөгжсөн Европын улс орнууд, АНУ болон зүүн өмнөд азийн зарим улс орнуудын төлөөллөөс түүвэр болгож авна

Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө:

- судалгааны удирдамж, болвсруулалтын арга хэлбэрийг захиалагч талд танилцуулан батлуулах
- судалгааны үр дүнд боловсруулалт хийж, дэлгэрэнгүй тайлан бичиж, судалгааны үр дүнг танилцуулж, эцсийн байдлаар хүлээлгэж өгөхдөө гэрээ дүгнэсэн акт үйлдэх

- судалгааны бүтээлийг энгийн ойлгомжтой хэрэглээний программ хэлбэрт оруулснаа тохируулгын хамт хүлээлгэн өгөх

Зөвлөхөд тавигдах шаардлага:

Судалгааны ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- ажил гүйцэтгэгч нь судалгааны чиглэлээр ажил гүйцэтгэсэн туршлагатай байх
- сүүлийн 3 жилийн хугацаанд зөвлөх үйлчилгээ звуулахдаа гэрээний үүргээ зөрчөөгүй байх
- ажлын даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвартай, 3-аас доошгүй мэргэшсэн судлаачтай байх
- захиалагчтай нягт хамтран ажиллаж, ажлын явц, үр дүнгийн талаар мэдээлэх, шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь уян хатан, шуурхай гаргаж өгөх

Судалгааны багийн гишүүдэд тавигдах шаардлага:

- судалгааны багийн ахлагч нь докторын зэрэгтэй байх
- судалгааны гишүүд нь бакалавр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх
- эдийн засагч, математикч, статистикч, социологич мэргэжилтэй байх
- мэргэжлээрээ Заас доошгүй жил ажилласан байх
- идэвх санаачилгатай, бүтээлч, багаар ажиллах чадвартай байх
- ажлыг богино хугацаанд гүйцэтгэх, ажлын даалгаврыг бүрэн биелүүлэх чадамжтай байх